

“Хөх судар” дахь В.Инжаннашийн нэгэн захиасын тайлал
(сурвалж бичгийн эхийн судалгаа)

Ш.Чоймаа*

Чухам, Хөх Монголын мандан бадарсан түүх хийгээд Богд Чингис өвгийнхөө үлитгэнгүй ач буян, эгнэшгүй эрдэм чадлыг түмэн үест дуурсган хоцоргохын төлөөнөө, “Монгол тоотон бүгдээр уг үндэс ба язгуур удмаа мэдтүгэй” хэмээж “бие, хэл, сэтгэлийг гүнээ чилээж” байж, эзэн Богд Чингисийн 28 дугаар үеийн үр, их бичгийн хүмүүн Ванчинбалын Инжаннаши бээр “Хөх судар” хэмээх нэгэн шалгарсан бүтээлийг хойчис биднээ үлдээжээ.

Инжаннаши “Хөх судар”-аа бичихдээ Монголын түүхийн 10 анги судар ашигласан хэмээн товчит толтдоо нэр дурдсан боловч, бас тэр арван анги сударт нэр оруулаагүй бусад олон сурвалжийг үзэж судалж байсан нь тодорхой байдаг. Үүнд, 59-р бөлгийн эцэст “Монгол алтан товч”, 5 дугаар бөлөгт “Илтгэл шастир”, 27 дугаар бөлөгт, “Чингис Богдын тахилын сан судар” зэрэг зохиолын нэр гарахаас гадна, 27-р бөлөгт: “Бядуу сударч би Энэ их Юань улсын 13 зүйлийн олон судар бичиг, цэдиг туужийн зүйлд үзвээс, Чингис хааны хүний эш хэлхээнд халдсан явдал үс хялгасны төдий ч үгүй” гэжээ.

Бр нь Инжаннаши “Хөх судар”-ыг бичихэд, үзэх ашиглах судар шастир хангалттай арвин байсныг “Товчит толт”-ын гуравдугаараас мэдэж болно. Тэнд өгүүлэхдээ, В.Инжаннаши бээр нэгэн бичгийн хүнээс Богд эзэн Чингисийн тухай олон зүйлийг шалгаан асуухад, тэр бичгийн хүн «... *Чи, туслагч ноёны (Ванчинбалын, Ш.Ч) хураасан таван тэрэг бичиг байтал, хүнээс асууж хашираах чинь юун? ... Туслагч ноёны зоож ноосон асар тулам (байшингийн адар тулам, Ш.Ч) дүүрэн хураасан судар гэрт чинь байтал, юунд айл хороог тойрч, аливаа хүнээс асууж, хүнийг энэ мэт хашираамуй?* » хэмээх зэргээр хилэгнэн уурласныг дурджээ.

Тэр бээр мөн Товчит толтын дөтгөөр ангид дурдсан нь: “*Тийнхүү энэ Чингис Богдын судар бичиг цэдэг тууж нь уйгур үсэг, шар үсэг, товд үсэг, хятад үсэг жич бас монгол манжийн зүйлийн судар гарсан нь маш олон*” гэжээ. Инжаннаш ийнхүү олон хэлний түүхэн товчисыг үзэж ашиглахдаа, өөр хооронд нь харгуулан тулгаж, хэргийн учир, он цаг, оноосон нэрсийг аль зөрсөн газар нь нарийвчлан мөшгиж судалгаа хийжээ. Юуны өмнө, түүхэн баримтад үнэнч байх

*Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

зарчмыг баримталж, мушгин гуйвуулсан, халууран ташаарсан үг үсгийг олж илрүүлж засаж залруулахыг хичээж байв. Ийн чармайж байсны нэг гэрч баримт нь энэ өгүүллийн агуулга юм. “Чингис хааны алтан товч нэртнийн цэдэг”, “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Алтан товч”, Саган сэцэний “Эрдэнийн товч”-д гардаг нэгэн богино домог буй бөгөөд утга нь, Эзэг Богд Чингис хаан бээр Хасар, Бэлгүтэй хоёр дүүгийнхээ бардам омгийг дарахаар нум сум худалдагч нэгэн бядуу дорой өвгөнд хувилж очоод, тэдний омгийг мохоосон өгүүлэмж юм. Энэ домгийг В.Инжаннаши “Хөх судар”-таа найруулан оруулжээ. Үүнд:

« ... Бөх Бэлгүтэй .. дүү хавт Хасарыг зүг хэлрүүн: Маны ах хэтэрхий ихээр аашлан, ханан (ханал, Ш.Ч) үгүй хүчирхэг (хүчирхэн?, Ш.Ч) явмуй. Бэлгүтэйн бөхөөр, Хасарын хаваар харьтан дайсныг хамгаалан, хагуу эсэргэцлийг зөөлтгөлөө. Эдүгээ таван өнгөтнийг эрхэндээ хураахуйд, бид хоёроос өөр хэн хүч өгөх! хэмээн хараахан гоморхон өгүүлэлдэхүйд, үзвээс, холоос хөх зүлгийг барьж, нэгэн туранхай өвгөн нэг үүрэг нум үүрч, айл бядан (хэсэн, Ш.Ч), худалдахаар ирсэнд, Бэлгүтэй эсрэг эчээд (очоод, Ш.Ч), нэгэн уртагчин нумыг авч, өгүүлрүүн: « Ай! Хөгшин чиний энэ нумаар чачуулины харингай [Энэ хоёр үсгийн (үгийн, Ш.Ч) учир нь ухагдахуй үгүй, халуурсан үг болов уу гэхүл, бас түүний ташааг олох үгүй тул, аймшиг үгүй санавчлан эс засаж, хуучин цэдиг судруудын ёсоор бичвэй. Эсхүл ямар нэгэн өчүүхэн араатан жигүүртний нэр ч болов уу, лав хуучин үг буй за. Эсхүл царцаахай харвах хэмээн басамжлан хэлсэн үг ч болов уу. Мэргэд бээр ялгагдахуй (ялгагтун, Ш.Ч)]» -н нум хийхээс бус юу хиймүй хэмээхүйд, тэр өвгөн хамраа шагнайн басамжлан, инээж өгүүлрүүн: «Таны хоёр залуус тэгш (ялгалгүй адилаар, Ш.Ч), далд хүнгүй газарт, тэнхээ хэрээ үл мэдэн, тэнцэшгүй их үг өгүүлнэм» хэмээгээд, нум юугаан авч өгсөнд, Бэлгүтэй хүйтнээр инээн хялайн харж, хүлээн аваад, хөлдөө доромтлон (дорд үзэн, Ш.Ч) хөвчилсүгэй хэмээн хөлсөө уртал оролдоод, гар хөл минчүүрч, хүч эс хүрээд, хүрэн царайгаа хөхөртөл ичгүүрч, гэдрэг өгсөнд, туранхай хөгшин тэсгэлгүй инээн, хоёр гараар нумыг шинэ саран мэт муруйлгаж, амаараа хөвчилж өгсөнөө (өгсөнд, Ш.Ч), Хасар аваад тэнхээгээ баргал татаж, нумын тэвхийг тамшилгаас салган эс чадвай ...»¹

гэх мэтээр бичсэн байдаг.

В.Инжаннаши бээр “Хөх судар”-аа бичихдээ энэ домгийг ямар сурвалжаас авав?, “Хуучин цэдиг судруудын ёсоор бичвэй” хэмээсний “Хуучин цэдиг судар” нь ямар зохиол буй?, Үгийн утгыг оноон олж чадалгүй, хожмын бидэнд найдан үлдээж, хаалтанд тусгайлан тэмдэглэл хийж орхисон “Чачуулины харингай (гарингай)” нь юу буй? зэргийг мөшгин тодруулахыг хичээв.

Энэ домог өмнө дурдсан дөрвөн сурвалжид лавтай байх бөгөөд В.Инжаннашийн утгыг эс олсон “чачуулины харингай” (čačaγulin-u qarinqγai) хэмээх үг бүхүй нь Саган Сэцэний “Эрдэнийн товч” юм. “Хөх судар”-аас өмнө эш татсан хэсгийг “Эрдэнийн товч”-д үзвэл:

«tendeče qasar belgütei qoyar nöküčen: ene ejen ber yosun ügei jasaylan: king ügei küčürken amui: qasar-yin qabu-bar: belgütei-yin böke-ber: qaritan-i qamγalun: qatayū-yi jögeledkelügei: edüge tabun önggeten-e ayalaqui-dur: bide qoyar-ača öbere ken j-c küčün öggümüi: kemejü omurqan aqu-yi anu: ejen ayiladuyad: keüked-ün omuy-i ečinegür daruy-a kemen sedkin: nigen douratu ebügen kümün bolun qubilju: nigen urtayčün numun-i qudaldur-a ayil bidun yabuqui-dur: qasar belgütei qoyar tus bolju üjged: ai ebügen činu ene numun-iyar čičüγulin-u γarangγ-a (~qarangγ-a)-yin numun kiküi-eče busu yaγun kikü:

¹ Инжаннаши “Хөх судар”, тэргүүн дэвтэр, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1959, 297-р тал

kemen dorumjilabasu: ebügen ta qoyar jalayus üjekü-yin urida-ača yakin dorumjilaqu: üjeju medekü bui j-a kemegsen-dür: elegleju iniyeged: belgütei köbçileju kücün ese kürüysen-dür: ebügen köbçileju ög-besü: qasar abuyad tataju ese dayabai ..»²

(Тэндээс Хасар, Бэлгүтэй хоёр нөхцөн, энэ эзэн бээр ёсон үгүй засаглан, жин³ үгүй (хуваарьгүй, Ш.Ч) хүчирхэж амуй. Хасарын хаваар, Бэлгүтэйн бөхөөр харьтныг хамхлан, хатууг зөөлтгөлөө. Эдүгээ таван өнгөтнөө (өнгөтөнд, Ш.Ч) аялахуйд, бид хоёроос өөр хэн зэ хүчин өгмүй» хэмээж, оморхон аху-г (байхыг, Ш.Ч) нь, эзэн айлдаад (болгоон мэдээд, Ш.Ч), хүүхдийн омгийг эчнээгүүр дарья хэмээн сэтгэн, нэгэн дорд өвгөн хүн болон хувилж, нэгэн уртагчин нумыг худалдараа (худалдахаар, Ш.Ч) айл бядан явахуйд, Хасар Бэлгүтэй хоёр тус болж (яг таарч, Ш.Ч) үзээд, “Ай! өвгөн чиний энэ нумаар чичуулины харанга (гаранга) (čičuylin-u qarangγ-a ~ γarangγ-a)-ын нум хийхээс бус, юун хийх хэмээн доромжилбоос, өвгөн та хоёр залуус үзэхийн урьдаас яахин доромжлох, үзэж мэдэх буй за хэмээсэнд, элэглэж инээгээд, Бэлгүтэй хөвчилж, эс хүрсэнд, өвгөн хөвчилж өгвөөс, Хасар аваад, татаж эс даавай...)

хэмээн бичсэн нь үзтэл “Эрдэнийн товч”-ийг ашигласан нь тодорхой буй. В.Инжаннаши бээр урнаар дүрслэх цөөн үгс нэмснээс бус, хэвээр нь авч бичжээ.

Өмнөх харьцуулгаас тодорсон зүйл хэмээвээс, В.Инжаннаши бээр нэрийг нь тодорхой дурдалгүй, “хуучин цэдиг судар” гэсэн нь Саган Сэцэний “Эрдэнийн товч” бөгөөд Хасар, Бэлгүтэй хоёрын омгийг дарсан тухай домгийг мөн “Эрдэнийн товч”-оос авсан ажээ. Яагаад ийнхүү шууд заах болов хэмээвээс, “Чингис хааны алтан товч нэрт цэдиг”, “Хаадын үндсэн хураангуй алтан товч”. Лувсанданзаны “Алтан товч”-д байгаа уг домог нь нэг уг сурвалжтай, адил хувилбарууд бөгөөд бидний тухайлан эрж буй “чичуулины гаранга” хэмээх үг үгүйгээс гадна, “Эрдэнийн товч”-ийнхоос өөр товч хувилбарууд байх аж.

В.Инжаннашийн хойчийн бидэнд даалгавар болгон захисан “чачуулины харингай” хэмээх үгийн тухай мөрдөн үзье. “Эрдэнийн товч”-ийн олон хувилбарт хэрхэн тэмдэглэв хэмээвээс:

№	Тухайн сурвалжийн хэвлүүлсэн хувилбарууд	Хэрхэн бичсэн
1	Өргөө эх: (1955 онд гэрэл зургаар Э.Хэйнишийн хэвлүүлсэн эх) 29-р тал (30 ^г)	čičuylin-u qarangγ-a (~γarangγ-a)
2	1956 онд А.Мостаэртын хэвлүүлсэн эхүүд: а. Part II 73-р тал (37 ^г) (ejen boyda činggis qaγan-u šara teüke orusiba) б. Part III 65-р тал (32 ^г) (erdeni-yin tobči kemekü-yin туγuji) в. Part IV 77-р тал (Хангин хошуунаас Шар зуугаас олсон, Хэшигбатын хуулсан эх)	čačiyulin-u qaringge čačiyulin-u qarangγ-a (~γarangγ-a) čačiyulin-u qarangγ-a (~γarangγ-a)

² Erich Haenisch, *Eine Urga-Handschrift des mongyolischen Geschichtsweks von Secen Sagang* (alias Sanang Secen), 1955., Akademie ver lag-Berlin, s.29 (30^г).

³ “Зуун үр тарианыг нэгэн хин хэмээж бичээд, чин (čing) хэмээж дуулдмуй. Бас хуваарь хэмээн мөн хэлмүй”. Qorin naimatu tayilburi toli, namjilm-a emkilebe, 1994, kökeqota, 913-р тал.

3	1958 онд Ц.Насанбалжирын хэвлүүлсэн эх: (4 эхийг харгуулсан) 90-р тал а. Өргөө эх б. “Tngri-deče jayaγabar egüdügen, qad- un uruy-un čayan teüke” в. “Sayan Sečen qung tayiji-yin erdeni-yin tobči” г. Бийрээр бичсэн тодорхойгүй эх	а. čičuyulin-u qarangγ-a (~γarangγ-a) б. čičayulin-u qarangγ-a (~γarangγ-a) в. čičayulin-u qarangγ-a (~γarangγ-a) г. čičiyulin-u qarangγ-a (~γarangγ-a)
4	1959 онд гэрэл зургаар Э.Хэйнишийн хэвлүүлсэн модон барын эх “enedkeg töbed mongγol qad-un čayan tegüke neretü tuyuji” (Манжийн Тэнгэрийн Тэтгэсэн хааны зарлигаар 1766 онд барласан) 65-р тал	čičayulin-u qarangγ-a (~γarangγ-a)
5	1962 онд Мэргэнбаатарын хэвлүүлсэн Алаг сүлдний эх 64-р тал	čičayulin-u qar(a~i)ngγai (~γar(a~i)ngγai)
6	Хөх-Өндөрийн 1987 онд хэвлүүлсэн Урадын өмнөд хошууны Жаргалант сүмээс олсон эх (qad-un ündüsün erdeni-yin tobčiy-a kemekü ogusiba) 79-р тал	čičayulin-u qaringγ-a (~γarangγ-a)
7	Монгол улсын Хэнтий аймгаас олдсон хулсан үзгийн эх (судрын 33-р тал)	činčayulin-u qaringγan (~γaringγan)

Дээр дурдсан эхүүд хаана, хэдийд хэвлэснийг жагсааваас:

1. Haenisch, E., Eine Urga-Handschrift des mongolischen Geschichtwerks von Sečen Sayang (alias Sanang Secen), Berlin, Akademie Verlag, 1955,
2. Mostaert, A., Erdeni-yin tobči, Mongolian chronicle by Sayang Secen, 4vols. Cambridge, Harvard Univ. Press. 1956
3. Ж. Насанбалжир, Ц., erdeni-yin tobči, ulayan bayatur, 1961
4. Haenisch, E., Der Kien lung-Druck des mongolischen Geschichtwerks Erdeni-yin tobči von Sayang Secen, Wiesbaden, Franz Steiner Verlag GMBH, 1959
5. mergenbayatur, qad-un ündüsün-ü erdeni-yin tobči, kökeqota, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1962.
6. Köke-öndür, qaryuγulun tayilburilaba, erdeni-yin tobčiy-a sayan sečen jokiyaba, bege9in, 1987 он.
7. Sayang Sečen, erdeni-yin tobči, A manuscript from Kentei Ayimaγ, by Elisabeth Chiodo und by Klaus Sayaster, Harassowitz Verlag, Wiesbaden. 1996.

Өмнө дурдсан Саган Сэцэний “Эрдэнийн товч”-ийн хувилбар эхүүдэд тохиолдох “чичуулины гаранга” хэмээх үгийн бичлэг нь зарим авиа үсгийн ноцтой бус өчүүхэн ялгаа байхаас бус, адилхан юм. Бидний үзсэн хувилбар эхүүдэд “γ”-ийн хоёр цэгийг тогтвортой бичээгүй тул “qarangγ-a” буюу “γarangγ-a” гэж галиглах, бас дуудах бүрэн боломжтой ажээ. Харин нэгэн зүйлийг ажиглахад, В. Инжаннаши бээр Мэргэнбаатарын хэвлүүлсэн Алаг сүлдний эхийн нэг хуулбарыг ашигласан мэт байнам.

Хожуу үеийн буюу 17-р зууны сурвалжаас Саган Сэцэний “Эрдэнийн товч”-ийг гадаад, дотоодод нэлээд эрт судалж, бас орчуулсан байдаг. Бидний тухайлан мөшгиж буй үгийг хэн, хаана, яаж орчуулсаныг дурдъя.

Манжийн Тэнгэрийн Тэтгэсэн хааны зарлигаар чин ван Цэнгүнжавын өргөсөн “Эрдэнийн товч”-ийг, монгол бичгээр нь 1766 онд модон бараар барлаж, мөн 1766 онд манжаар, 1777

онд хятадаар орчуулж хэвлэсэн түүхтэй аж. Манж Чин улсын Гадаад Мужийг Засах Явдлын яамны баруун этгээдийн дэд түшмэл Үлэмж бээр зуны гурван сарын хугацаанд манжаар орчуулж дуусгажээ. Үлэмжийн барьж орчуулсан “Эрдэнийн товч”-ийн модон барын монгол хэвлэлд, “*ciṣayulin-u qaranga*” гэж байх бөгөөд манжаар “*ai sakda sini ere beri manggai cooci-yunli-be[=coociyali-be] tanggilara tanggilakô arara ci tulgiyen umai baitala ba akô*” (Ай хөгшин, чиний энэ нумаар дөнгөн ядан цууцалийг харвах бөмбөгөн нум хийхээс гадна огт хэрэглэх газар үгүй...)⁴ гэж орчуулжээ. (“*Цууцаль*” гэдэг нь *цахлай, дэглийтэй тостэй, загас жарсахай зэргээр хооллодог нүүдэлчин шувуу бөгөөд “бөмбөгөн нум” гэдгийг “Хорин наймтын толь”-д тайлснаар бол “Бөмбөг үсэргүүлэн харвах гичиргүй өчүүхэн нум” ажээ.*)

Хятад орчуулга нь манж орчуулгыг дагасан бөгөөд “*老兒此弓除作打鳥之彈弓並無用處 lǎo ér cí gōng chǐ zuò dā niǎo zhī dàn gōng bīng wú yòng chǔ*”⁵ (- Ай хөгшин! Энэ нум чинь шувуу харвах нум төдийхнөөс, өөр юунд ч хэрэг үгүй болой...) гэжээ.

1981 онд Дорнотив “Шинээр харгуулж тайлбарласан Эрдэнийн товч” гэх номдоо “чичуулин” гэсэн үгийг манж орчуулгыг даган “цууцаль шувуу” (沙溜子 *shā liū zi*) гэж орчуулжээ.

Өрнөдийн орнуудад “Эрдэнийн товч”-ийн орчуулга нэлээд эрт түгсэн. 1829 онд И. Я. Шмидт германаар орчуулж хэвлэсэн, хожим 1985 онд В. Хайссиг И. Я. Шмидтийн орчуулгыг хянаж, дахин хэвлүүлсэн. Тэдгээр орчуулгад “чичуулины гаранга” хэмээх үгийг “*Schnellbogen für Maulwürfe*”⁶ “Сохор номин харвах хөнгөн нум” гэж орчуулжээ. Хятадын эрдэмтэн Улаан “Эрдэнийн товчийн судлал” хэмээх номын хятад хэвлэлд “чичуулины гаранга” хэмээх үгийг мөн сохор номин (бухлаг хулгана)-ы нум (鼯鼠的弓子 *yǎn shǔ de gōng zi*)⁷ гэж орчуулсан байх аж.

1964 онд Ж. Р. Крюгер бээр “Эрдэнийн товч”-ийн нэгдүгээр хэсэг буюу 1-4 дүгээр бүлгийг, 1967 онд 1-5 дугаар бүлгийг англиар орчуулж, тус тус Блүүмингтонд хэвлүүлсэн бөгөөд бидний мөшгиж буй үгийг “*a string for a mole-trap*”⁸ (Сохор номингийн хавхны хөвч) гэж орчуулжээ. Саган Сэцэний “Эрдэнийн товч”-оос В. Инжаннашийн эш татан авсан “чичуулины гаранга” хэмээх үгийн утгыг дээр дурдсан орчуулгуудад төдийлөн зөв оноож чадсангүй.

“*ciṣuyulin*” буюу “чичүүл” гэдэг нь “Оготно овгийн төрөл. Монголд монгол чичүүл, шар чичүүл, сухайн чичүүл гэх гурван зүйл тархсан. Биеийн урт 11,0-14,5 см, сүүл нь 8,6-12,2 см, бор шаргал зүстэй, жилдээ хоёр удаа төрж, тэр бүрийдээ 3-8 гөлчгий гаргадаг, олон

⁴ Haenisch, E., *Monggo han sai da sekiyen, die Mandschufassung von Secen Sayan's mongolischer geschichte*, Leipzig, Verlag Asia Major GmbH, 1933, s.38

⁵ “Эрдэнийн товч” (蒙古源流), Жүнхуа бичгийн хорооны 1962 онд дахиж дармалласан Шэнь Чэн Жи (沈曾植), Жан Эл Тянь (张尔田)-ий “Эрдэнийн товчийн тайлбар нутлал” (蒙古源流笺证) гэх дэвтэр. Чин улсын үеийн хятадчилсан дэвтэр, 63^о тал.

⁶ - *Geschichte der Ost-Mongolen und Jhres fürstenhauses, verfasst von ssanang ssetsen chungtaidschi der Ordus, Aus dem Mongolischen übersetzt von I.J.Schmidt, St.Peterburg, 1829, s. 73.*

- *Sayan Sečen, Geschichte der Mongolen und ihres Fürsten hauses, Herausgegeben und mit einem Nachwort von Walther Heissig, Manesse Verlag, Zürich, 1985, s. 101.*

⁷ “Эрдэнийн товч”-ийн судлал”, Улаан зохиов, (хятад хэлээр), 2000 он, Бээжин, 152 дугаар тал.

⁸ John, R. Krueger, *Sagang Sechen, Prince of the Ordos Mongols, The Bejewelled Summary of the origin of Khans (Qad-un ündüsün-ü Erdeni-yin Tobči)*, Part one: Chapters One through Five, Bloomington, 1967, s. 49.

амсартай үлий (нүх) ухаж амьдардаг, ургамлаар хооллодог”⁹ амьтан болно. Одоо ч чичүүл гэж ярьдаг. Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д байгаа тул Ордос нутгийн аялгуунд лавтай байгаа хэмээн бодож, А.Мостаэрт аругайн “Ордос толь”-ийг үзэв. Тэнд:

“[džitsūli dans šara džitsūli espese de rat des champs.Voir s.v. хүлүгүна [mo. čičayulin, čičuuli]¹⁰ (Жичууль- шар жичууль- хөдөө хээрийн хулганын төрөл зүйл. Хулгана [монгол бичгээр чичагулин, чичуули]-ийг үз!) хэмээн тов тодорхой тэмдэглэж, мөн “(хүлүгүна džitsūli (~ džitsūl) rats (en général)” (хулгана жичууль (хулганын ерөнхий нэр)¹¹ хэмээн бичжээ.

Чичууль ~ чичүүл гэдэг үгийн гарлыг Алтай язгуурын хэлнүүдийн хүрээнд харьцуулан үзэх боломжтой аж. Түрэг төрлийн хэлнүүдэд хулганыг “сычкан, чычкан, тышкан, шыган, шышкан (schog), сычан”¹² гэх мэтээр нэрлэдэг бөгөөд XI зууны Махмуд Кашгарын толь бичигт “sīčyan” (мышь=хулгана), “sīčyan jīlī” (календарь, год мыши, название года в двенадцати летнем животном цикле)¹³ гэж буй.

Тэдгээрийн язгуур бүтээвэр нь “сыч-, чыч-, тыч-” тул “čičayuli” (чичууль ~ чичүүл) хэмээх монгол үгтэй нэг язгуур болох нь тодорхой байна. В.Инжаннашийн утгыг эс ухсан “čičayulin” хэмээх үгийн учир тод болов.

Харин “qaringγai” хэмээх үгийн тухайд бол “γarangγ-a” хэмээх үг бөгөөд “Хорин нэгт тайлбар толь”-д “üne (üyen) görügeleku yaγuman-u ner-e”¹⁴ (үнэ (үен) гөрөөлөх юмны нэр) хэмээсэн бол Я.Цэвэл гуай “Монгол хэлний товч тайлбар толь”-доо “үнэг (үнэ ~ үен!) зэрэг жижиг амьтныг гөрөөлөх зэвсэг, гаранга тавих”¹⁵, Ц.Норжин нарын “Монгол хэлний толь”-д “Хэрэм зэрэг жижиг амьтныг гөрөөлөх, зэв нумтай нэгэн зүйлийн хавх”¹⁶, Сэцэнцогт “Монгол үгсийн язгуурын толь”-доо “arangγ-a” (аранга) ч гэж хэлдгийг заагаад “үнэ (үен), хэрэм зэрэг амьтныг гөрөөлөх зэмсэг”¹⁷ хэмээн тайлбарлажээ.

“Таван хэлний толь бичиг” (XVIII зуун)-д манжаар dadari, төвдөөр ᠪᠢᠮᠳᠠ (byi-mda’) [үгчлэн орчуулбал, хулганы сүм], монголоор γarangq-a, уйгураар susar tuzay, хятадаар “хулгана агнах сааль занга”¹⁸ хэмээжээ. Төвдөөр бичсэн ᠪᠢᠮᠳᠠ (byi-mda’) хэмээсэн үгийг Сумадираднагийн “төвд монгол толь бичиг”-т үзвэл, “γarangγa, üne görügečilekü jangγ-a” хэмээн орчуулжээ.

Нэгэнтээ “чичүүл” хэмээх огогнын төрлийн хулгана зурамтай төрөл зүйл нэг амьтны нэрийг өгүүлсэн тул бас нэгэн эндүүрэл байдгийг хамтад нь залруулан бичсүгэй.

⁹ “Монголын нэвтэрхий толь” II боть, Н-Я, ШУА, УБ, 2000, 1117 дугаар тал.

¹⁰ *Dictionnaire Ordos*, par. Antome Mostaert, C.I.C.M, Troisième Édition, A-Z, Tables Alphabétiques, C.I.C.M.-A.M.C. Ulaanbaatar, 2009, s.205.

¹¹ Дээрх толь бичгийн 367 дугаар тал.

¹² - Самойлович, А.Н., “К вопросу о 12 - летним животном цикле у турецких народов”, Тюркские языковедение, Филология, Руника, Москва, 2005, стр. 241.

- Радлов, В.В., *Опыт словаря турецких наречий*, Томь четвертый, Санкт-Петербург, 1911, стр. 1060.

¹³ *Древнетюркский словарь*, Редакторы: В.М.Наделяев и др., АН СССР, Издательство “Наука”, Ленинград, 1969, стр. 502.

¹⁴ “*Qorin niǰetü tayilburi toli*”, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriγ-a. 1979, 450 дугаар тал

¹⁵ Я.Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь” УБ, 1966. 139-р тал.

¹⁶ Norjin, “*Mongγol kelen-ü toli*”, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriγ-a, 1999, 1649 дүгээр тал

¹⁷ “*Mongγol üges-ün iǰar-un toli*”, sečenčoytu nayirayulba, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriγ-a, 1988, 147 дугаар тал.

¹⁸ *Tahin jüül-ün üstig-iyer qabsurırsan manju ügen-ü toli bičig*, ündüsüten-ü keblel-ün qoriγ-a. begejing. 1957. II боть, 3071-р тал.

“Чингисийн есөн өрлөг лүгээ өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” хэмээх монголын эртний уран зохиолын нэгэн сайхан дурсгалыг хэн бүхэн мэднэ. Уг зохиол Лувсанданзаны “Алтан товч”, Рашпунцагийн “Болор эрих”, В.Инжаннашийн “Хөх судар” (ихэд найруулсан хувилбар), 1925 онд Тэмгэтийн “Чингис хааны цэдиг” нэртэй хэвлүүлсэн “Хураангуй алтан товч”-д хавсаргасан хэдэн зүйлийн зохиол дотор тус тус багтсан байдаг. Уг зохиолд өнчин хөвгүүн бээр архины гэм хорыг уран цэцэн өгүүлэхэд, Чиндага сэцэн ховшуур хилэгнэж өгүүлэхдээ:

“Холбож хэлэх үгтэй аж л чи
Хосолж санах цээжтэй аж л чи
Хулгана битүр (мэт) биеийг чинь хугачнам би
Хурсан бүгдэд инээдэм болгоном би
Чучали мэт биеийг чинь цуучнам би
Цугласан бүгдэд элэг болгоном би”¹⁹

хэмээн өгүүлдэг. Монгол шүлгийн эн зэрэгцүүлэх ёсоор, утга давтан лавшруулан өгүүлэхдээ, ойролцоо утгат үгийг хэрэглэдэг. Тэрхүү зарчмаар бол “хулгана мэт” хэмээсэнтэй төстэй үгийг давтан өгүүлэх ёстой байранд буй үгийг Лу.”Алтан товч”-д *šičali*²⁰, “Чингис хааны цэдиг”-т *šičūli*²¹, Рашпунцагийн “Болор эрих”-д *šaqulai*²² гэж бичсэн байдаг. Лувсанданзаны “Алтан товч”-ийг Ц.Шагдар 1957, 1990 онд кирилл үсэгт буулгахдаа “цучил”²³ (хагас шатсан түлээ мод, Ш.Ч) хэмээн буулгасан тул өрнөдийн судлаачид буруу ухаж, орчуулахад нөлөөлсөн бололтой.

Н.П. Шастина оросоор, “Я же проткну твое [хилое] тело, подобное *огарку*”²⁴, Charles R. Bawden англиар, “I shall break up your body like a *scorched stick*”²⁵, Ц.Сүхбаатар, Мутomba Мукэнга нар францаар “Moi, je reux fendre corps comme de la *buchette*”²⁶ хэмээн тус тус орчуулжээ. В.Хайссиг германаар, “Den leib werde ich dir zerreißen wie den einer Feldratte!”²⁷ хэмээн орчуулсан нь “чичуулин ~ чичүүл” хэмээх үгийг зөв ойлгосон бөгөөд харин “Feldratte” хэмээх герман үг арай оноогүй байж магадгүй. МУИС-ийн биологийн эрдэмтэн багш нарын хийсэн толь бичигт германаар “*Renmmaus*” хэмээсэн буй.

¹⁹ Лувсанданзан, “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой”, гэрэл зургийн эх, Оршил бичиж хэвлүүлсэн Ш.Бира, Улаанбаатар, 1990, 796, 80а тал

²⁰ Лувсанданзан, “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой”, гэрэл зургийн эх, Оршил бичиж хэвлүүлсэн Ш.Бира, Улаанбаатар, 1990, 796 тал

²¹ “*činggis qaγan-u čedig*” 1925 (Хорголжин бар), Бээжингийн монгол бичгийн хороо, 145 дугаар тал

²² “*Bolur erike*”, Rasipungsuy jokiyaba, Köke öndür qaγayulun tulyaba, öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1985, 81 дүгээр тал.

²³ а. “Алтан товч” хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар улсын хэвлэлийн газар. УБ, 1957.

б. Лувсанданзан “Алтан товч” хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар редактор Ц.Ишдорж. УБ, 1990. 91-р тал

²⁴ Лувсан-Данзан, “Алтан товч” /“Золотое сказание”/. Перевод с Монгольского, введение, комментарий и приложения Н.П.Шастиной, Москва., 1973. стр. 172.

²⁵ *Mongolian Traditional Literature an anthology*, selected and translated by Charles R. Bawden, Kegan paul, London., New York., Bahrain, 2003, s.152

²⁶ “*La logomachie d’un orphelin vis-à-vis de neuf grands officiers de cinggis khan*” хэвлэлд бэлтгэж, францаар орчуулсан Ц.Сүхбаатар, Мутomba Мукэнга. УБ, 1995. 8-р тал.

²⁷ Helden-, Höllenfahrts- and Schelmengeschichten der Mongolen, Ausdem Mongolischen übersetzt von walther Heisig, Zürich, Manesse verlag 1962, s.75.

Мөн зарим судлаачид цууцаль шувуу хэмээн эндүү тайлбар ч хийсэн байдаг. Жишээ нь: Дөнгөж саяхан Д.Пүрэвдорж Лувсанданзаны “Алтан товч”-ийг шинээр хөрвүүлэн, тайлбар хийж хэвлүүлжээ. Тэнд бидний өгүүлэн буй хэсгийг

“Хулгана бидэр* биеийг чинь хугачанам, би
Хурсан бүгдэд инээдэм болгом, би
Цууцаль* (бялзуухай) мэт биеийг чинь цуучанам, би
Цугласан бүгдэд элэг болгоном, би”²⁸

хэмээн хөрвүүлээд “bitür → vтар⁴ ~ мэт” гэсэн үг болон “šičali” (šičayuli) хэмээсэн ташаа бичлэгт үгст алдаатай тайлбар хийжээ.

Энэ үг нь Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д гарсан “чичуулин” (чичууль ~ чичүүл) мөн бөгөөд шүлгийн эн зэрэгцүүлсэн давталтын утга ч тохирч буй. Үүнийг давхар батлах нэгэн баримт бол тод үсгээр бичсэн “Чингисийн есөн өрлөг лүгээ өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” юм. Хэдэн жилийн өмнө ХБНГУ-ын Гёттинген хотын номын санд суухдаа, тэнд хадгалагдаж байгаа тод үсгийн цөөн дурсгалыг сурвалжилсаар олж үзэж, энэхүү зохиолыг хуулж авсан билээ. Хар, улаан бэхийг хослуулан, тод үсгээр маш сайхан бичсэн судар байсан. Тэр сударт, бидний эш татсан хэсгийг бичихдээ:

“Ховшуур цэцэн хилэгнэж ийн хэмээн өгүүлрүүн:
Хулгана мэт биеийг чинь хугачнам, би,
Хурсан бүгдийн элэг болгоном, би, муу хөвүүн!
Чичүүл (šičiüle) мэт биеийг чинь чичнэм (šičinem), би.
Чуулсан бүгдийн инээдэн болгоном, би, үг-бээн тат”²⁹

хэмээжээ. Монгол бичгээр байсан судраас тод үсгээр буулгасан нь лавтай бөгөөд уг эх нь эртний алдаа багатай шастир байсан бололтой.

“Хулгана мэт биеийг чинь хугачнам, би ...
Чичүүлин мэт биеийг чинь чичнэм, би ...”

хэмээсэн нь эртний зөв хувилбар хэмээн үзэж болох буй за. “Хулгана мэт” хэмээсэн санааг ойролцоо үгээр давтан өгүүлэхэд, галын цуцал ч, цууцаль шувуу ч үл тохирох нь тайлбарлалтгүй зүйл болно.

Монголын түүх, уран зохиолын дээрх сурвалж бичгүүдэд бичлэгийн зөрөөтэй тохиолдож судлаачид, орчуулагчид, хөрвүүлэгчид янз янзаар ойлгож ирсэн “šičayulin” (чичуулин → чичүүл) хэмээх үг нь оготно хулганын төрлийн амьтан бөгөөд Монголд тархсан нь:

²⁸ Лувсанданзан “Алтан товч”, шинээр орчуулж, тайлбар хийж, оршил бичсэн Оюут овгийн Д.Пүрэвдорж. УБ. 2009. 213. 216-р тал


²⁹ Тод үсгийн судрын галиг:

qobšour šečen kilengle...i eyin kemen ögüülerün:
quluyuna metü beyei šini quyučinan bi
quraγsan bugudeyin eleq bolγui-nam bi. mou köböün
šičiüle metü biyei šini šičinem bi
šuułγsan bugudeyin inēden bolγonom bi. uge-bēn tata


- «1. Монгол чичүүл, *Meriones unguiculatus* Milhe - Ed.,
Когтистая Песчанка
Mongolian Gerbil
Mongolische Rennmaus
2. Сухайн чичүүл, *Meriones tamariscinus* Pall.,
Гребенчуковая Песчанка
Tamarisk Gerbil
Tamarisken - Rennmaus
3. Шар чичүүл, *Meriones meridianus* Pall.,
Полуденная Песчанка
Southern Jird or Midday Gerbil
Mittags Rennmaus
4. Морин чичүүл, *Rhombomys opimus* Licht.,
Большая Песчанка
Grand or Great Gerbil
Grosse Rennmaus»³⁰ хэмээсэн дөрвөн зүйл ажээ.

Эдгээрийг дүгнэн хэлбэл, “Гаранга” хэмээх нь оготно, чичүүл, үен, хэрэм зэргийг агнахад зориулсан саальтай төс бүхий зэв нумтай нэгэн зүйлийн хавх занга мэт зэвсгийг хэлдэг ажээ. Монголын тал хээрт яваа Хасар, Бэлгүтэй хоёр бээр өөрсдийн хүүхэд ахуйдаа хулгана, чичүүл, зурам зэргийг агнаж байсан үеийнхээ тоглоом мэт санагдах зүйлтэй зүйрлэн басамжилсан болох нь учир шалтгаан, нөхцөл байдалд ч тохирох билээ. В.Инжаннашийн захиасыг мөшгин тайлбарлаваас ийм буюу.

³⁰ Ричард П.Рийдинг, Д.Сумъяа, Р.Самъяа, Н.Батсайхан, “Монголын сээр нуруутан амьтдын нэрсийн толь бичиг” УБ, 1994, 52-р тал.



Академич Ш.Бирагийн 1990 онд гэрэл зургаар хэвлүүлсэн Лувсанданзаны Алтан товч-ийн 79b, 80a талаас



Саган Сэцэний Эрдэнийн товч-ийн өргөө эхээс, (1955 онд Э.Хэйнишийн гэрэл зургаар хэвлүүлсэн эхийн 29-р тал буюу 29v, 30r)

1. Өмнөд хэсэгт
 2. Өмнөд хэсэгт
 3. Өмнөд хэсэгт
 4. Өмнөд хэсэгт
 5. Өмнөд хэсэгт
 6. Өмнөд хэсэгт
 7. Өмнөд хэсэгт
 8. Өмнөд хэсэгт
 9. Өмнөд хэсэгт
 10. Өмнөд хэсэгт

ХБНГУ-ын Гөттинген хотын номын санд буй тод үсгийн эхээс

1. Өмнөд хэсэгт
 2. Өмнөд хэсэгт
 3. Өмнөд хэсэгт
 4. Өмнөд хэсэгт
 5. Өмнөд хэсэгт
 6. Өмнөд хэсэгт
 7. Өмнөд хэсэгт
 8. Өмнөд хэсэгт
 9. Өмнөд хэсэгт
 10. Өмнөд хэсэгт

1925 онд Бээжингийн монгол бичгийн хорооноос хэвлүүлсэн Чингисийн цэдэг дэх хэсгээс